# ХЭНТИЙ АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
## 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | ЗГТА-БТСУХорооны Стратеги төлөвлөгөө 2021-2024, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Байгууллагын стратеги төлөвлөгөө 2021-2024 | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилго 1. Идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх /эрүүл мэндээ хамгаалах, сайжруулах/ нөхцөлийг бүрдүүлж, олон нийтэд хүртээмжтэй болгох** | | | | | | | | |
| 1 | Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төрийн болон төрийн бус байгууллагын, уялдаа холбоог сайжруулах | | | | | | | |
| 1.1. | **Арга хэмжээ:1.1** Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилыг норм, нормативыг насны ангиллаар мөрдүүлж, нас, хүйс, эрүүл мэндийн байдалдаа хяналт тавих, биеийн онцлогт тохирсон дасгал, идэвхтэй хөдөлгөөн хийх арга зүй, спортоор | | Бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдсан иргэдийн А, В үнэлгээтэй хүн амын хувиар | 2023 онд 4200 иргэн буюу 9% | Сорилд хамрагдагсдын А, В үнэлгээтэй иргэд нийт иргэдийн 8.1% аас багагүй | Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорилд жилийн байдлаар аймгийн хэмжээнд 03-64 насны 6500 иргэн хамрагдаж А,В үнэлгээтэй иргэдийн тоо 2467 байгаа нь 9,4%-аар өссөн. Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорилд хамрагдагчдаас А, В үнэлгээтэй иргэд нийт иргэдийн 37,9% | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хичээллэх жишиг хөтөлбөрийг боловсруулах, иргэдэд хүргэх хүртээмжийг сайжруулах | | | | | | | |
| 1.2. | **Арга хэмжээ:1.2** Сумдад орон тооны биеийн тамирын арга зүйчийг үе шаттай ажиллуулна. | - | 3 хүртэл сумдад шинээр орон тооны арга зүйчид томилогдсон эсэх | 2 суманд орон тооны арга зүйч ажиллаж байна. | Шинээр 1-ээс доошгүй суманд орон тооны арга зүйчид томилогдсон байна. | 2024- онд Батширээт, Дадал, Баянмөнх, Галшар, Хэрлэн, Мөрөн, Баян-Адарга, Батноров гэсэн 8-н сум орон тооны арга зүйч томилуулан ажиллаж байна.Цаашид бүх сумдыг арга зүйчтэй болгох чиглэлийг сумдын Засаг дарга нарт өгч, хамтран ажиллах гэрээнд заалт болгон оруулсан. | 90 | 90. |
| 1.3. | **Арга хэмжээ:1.3** Биеийн тамир, спортын чиглэлд төрийн зарим чиг үүргийг гэрээний дагуу төрийн бус байгууллагад шилжүүлэн дэмжлэг үзүүлнэ. | 50 сая /УТ-ний зардал/ 5 сая /ЗДҮАХХАХЗ/ | Гэрээгээр ажил гүйцэтгүүлсэн төрийн бус байгууллагын тоо | 2 | 2-оос доошгүй . | Биеийн тамирын чиглэлээр 2024 онд БТСГазар нь "Мөнхийн хайрын урсгал" төрийн бус байгууллага, "Сувдан"dance бүжгийн клубтай тус тус хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаа.Мөн спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг холбоо, клубүүдтэй хамтран ажиллаж байна. | 100 | 100. |
| 1.4. | **Арга хэмжээ:1.4** Нийтийг хамарсан үндэсний болон нийтийн биеийн тамир, бүх нийтийн спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгуулагуудыг түшиглэн биеийн тамираар хичээллэгсдийг нэмэгдүүлнэ. | 92.3 сая /БТ-ын зардал/ | Биеийн тамираар хичээллэгчдийн тоо | 2023 онд биеийн тамирын 85 арга хэмжээнд 15110 иргэн хамрагдсан. | Биеийн тамираар хичээллэгчдийн тоо 8000-аас доошгүй байна. | 2024 оны жилийн эцсийн байдлаар БТСГазар нь "Мөнхийн хайрын урсгал" төрийн бус байгууллага, "Сувдан" Dance бүжгийн клубтай тус тус хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж өглөө бүр 06:00 цагаас 07:30 цагийн хооронд иргэдэд үнэ төлбөргүй биеийн тамирын үйлчилгээ / өглөөний дасгал,шугаман бүжиг, нийтийн бүжиг, бүх насныханд софт волейбол, бадминтон зэрэг төрлүүдээр чөлөөт тоглолт/ үзүүлэн ажиллаж байна. Биеийн | 100 | 100. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тамирын 60 арга хэмжээ БТТТогтоох сорилыг аймгийн хэмжээнд зохион байгуулж нийт Биеийн тамирын арга хэмжээнд давхардсан тоогоор 16120 болж өссөн үзүүлэлтэй байна. Иргэдийн дунд Нийтийн биеийн тамирын чиглэлээр Соёл, спортын бүтээлч сар аян, “Эрүүл Монгол Хүн” Үндэсний хөдөлгөөний сарын аяныг тус тус зохион байгуулсан. | | |
| 1.5. | **Арга хэмжээ: 1.5** Аймгийн Засаг даргын нэрэмжит “Төрийн албан хаагчдын спортын наадам” зохион байгуулна. | 10 сая /ЗДҮАХХАХЗ/ | 2 жил тутамд 1удаа зохион байгуулсан байна. | 2022 онд амжилттай зохион байгуулсан. | 2024 онд Аймгийн Засаг даргын нэрэмжит “Төрийн албан хаагчдын спортын наадам”-ыг амжилттай зохион байгуулах. | Хэнтий аймгийн Төрийн албан хаагчдын спортын Анхдугаар наадмыг 2024 оны 4 дүгээр сарын 1-5-ны өдрүүдэд Чингис хотод амжилттай зохион байгууллаа. Спортын наадамд 18 сум, 2 тосгоны 36 байгууллагын 1000 гаруй төрийн албан хаагчид хамрагдлаа. | - 100 | 100 |
| 1.6. | **Арга хэмжээ: 1.6** Бүх нийтийн болон нийтийн биеийн тамирыг хөгжүүлэхэд спорт цогболбор байгуулах | | Спорт цогцолбор байгуулах бэлтгэл ажлыг хангах хандивын аяныг эхлүүлэх | 2023 оны хагас жилд Хэрлэн суманд Хэрлэн лаборатори 1-р сургуулийн спорт заал, 1 тэрбум 300 сая төгрөгийн өртөг бүхий 300 хүний суудалтай Хэрлэн 4-р сургуулийн спорт заал, сүүлийн хагас жилд Өмнөдэлгэр 8,9 | Биндэр, Баян-Овоо сумын спорт заал ашиглалтанд орсон байна. | Бүх нийтийн болон нийтийн биеийн тамирыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн улсын төсөт хөрөнгийг суулгаж өгснөөр 2024 оны хагас жилийн байдлаар Жаргалтхаан суманд 8 тэрбум төгрөгийн өртөг бүхий сургуультайгаа хамт шинэ заал, Баянмөнх суманд 1.9 тэрбум төгрөгийн өртөг бүхий шинэ заал, Өмнөдэлгэр суманд 9.8 тэрбум төгрөгийн өртөг бүхий сургуультайгаа цуг шинэ заал тус тус 3 сард ашиглалтанд орсон бол Биндэр суманд 1 тэрбум төгрөгийн өртөг бүхий шинэ заал | 100 | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тэрбум төгрөгийн өртөг бүхий спорт заал, Жаргалтхаан суманд 8,1 тэрбум төгрөгийн өртөг бүхий сургуультайгаа цуг спорт заал тус тус Улсын төсөвт хөрөнгөөр шинээр ашиглалтанд орсон. | | гүйцэтгэл 95 % тай явагдаж байна. | | |
| | | | | | | | | |
| **Зорилго 2: Биеийн тамир, спортын бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангах, иргэдэд үйлчлэх спортын арга хэмжээг нэмэгдүүлж, спортын барилга байгууламжийн тоог нэмэгдүүлэх** | | | | | | | | |
| 2 | Спортын сургалт, дасгалжуулалтын үр дүнд тулгуурлан өсвөр үеийн шигшээ багийн тамирчдын спортын амжилтыг улс, олон улс, тив, дэлхийн түвшинд хүргэх | | | | | | | |
| 2.1. | **Арга хэмжээ:2.1** Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг клубын системд шилжүүлнэ. | | Шигшээ багийн клубын тоо | 2023 оны байдлаар шигшээ багийн төрлүүдээс 18 спортын төрөл клубтэй байна. | Шигшээ багийн клубын тоо нэмэгдсэн байна. | Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөр үеийн шигшээ багийн үйл ажиллагааг клубын системд шилжүүлэх зорилгоор 2021 оноос шигшээ багийн төрлүүд дээр спортын клубуудын тоог нэмэгдүүлэн ажиллаа. Үүнд: 2020 онд 6 спортын төрөлд 6 клуб, 2021 онд 9 спортын төрөлд 12 клуб, 2022 онд 9 спортын төрөлд 15 клуб, 2024 онд шигшээ багийн 10 спортын төрөлд 16 клуб үйл ажиллагаа явуулж байгаа нь шигшээ багийн тамирчдын техник, ур чадвар, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, өрсөлдөөнийг бий болгож, бодит үр дүнгээ өгч байгаа нь шигшээ багийн тамирчдын гол үзүүлэлт | 100 | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | болох УАШТэмцээнд үзүүлсэн амжилт нь жил тутамд тогтмолжин, өсөж байгаагаар илэрхийлэгдэж байна. | | |
| 2.2. | **Арга хэмжээ:2.2** Спортын амжилт гаргасан тамирчин, түүний дасгалжуулагчдад шагнал, урамшуулал олгох | | Тамирчин, дасгалжуулагчдад олгосон мөнгөн шагналын дүн тамирчдын тоо | 2023 онд 78 тамирчин, 16 дасгалжуулагчид нийт 14336000 төгрөгийн урамшуулал олгосон. | Амжилт гаргасан тамирчин, түүний дасгалжуулагч /50-аас доошгүй тамирчин/-ыг 10 саяас багагүй төгрөгийн шагнал урамшуулал олгох | Шигшээ багийн 9 спортын төрөлд УАШТэмцээнд амжилт гаргасан 85 тамирчдад 6,520.000/зургаан сая таван зуун хорин мянга/ төгрөгийн урамшууллыг олгосон. | 100 | 100 |
| 2.3. | **Арга хэмжээ:2.3** Секц, дугуйланг тогтмол хичээллүүлж, багш, дасгалжуулагчдын бэлтгэл, сургалтын хөтөлбөртэй болно. | - | Спортын дугуйлан /секц/-д хамрагдагчдын тоо, багш, дасгалжуулагчдын бэлтгэл, сургалтын хөтөлбөртэй болсон эсэх | 2023 онд нийт 19 спортын төрлөөр 60 секц дугуйланд 890 тамирчин хамрагдсан. | Спортын дугуйлан /секц/-д хамрагдагчид тоо 850-аас багагүй байх | 2024 онд нийт спортын 57 секц дугуйланд 855 тамирчид хамрагдаж байна. 2024 онд шигшээ баг нь спортын 15 төрлөөр нийт 5760 цагийн сургалт-дасгалжуулалтын үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан. | 90 | 90 |
| 2.4. | **Арга хэмжээ:2.4** Өсвөрийн шигшээ багийн тамирчдын тоог нэмэгдүүлж, хэрэглэл, материалаар хангах | 150 сая /ЗДҮАХХАХЗ / | Өсвөрийн шигшээ багийн төрөл, тамирчдын тоо | 2023 онд 15 спортын төрөл 363 тамирчин, материаллаг баазыг бэхжүүлэхэд 26130,0 сая төгрөг зарцуулсан. | 15 спортын төрөл 270-аас доошгүй тамирчин | Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөр үеийн шигшээ баг нь спортын 15 төрөлд, 367 тамирчин хичээллэж байна. | 100 | 100 |
| 2.5. | **Арга хэмжээ:2.5** Аймгийн хэмжээнд спортоор | | Спортоор хичээллэгчдийн тоо | 2023 онд 4979 | 6100-д хүргэнэ. | Аймгийн хэмжээнд 2024 оны байдлаар 6055-оор хичээллэж байна. | 100 | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хичээллэдэг иргэдийн тоог нэмэгдүүлнэ. | | | | | | | |
| 2.6. | **Арга хэмжээ:2.6** Спортын магадлан итгэмжлэлд хамрагдах спортын клуб, фитнес клубын тоог нэмэгдүүлэх | 3,5 сая /БТ-ын зардал/ | Спортын магадан итгэмжлэл авсан клубын тоо | Магадлан итгэмжлэлд орсон клуб байхгүй | 1 клуб магадлан итгэмжлэгдсэн байна | "ХАДУН" фитнес клубыг БСШУС-ын сайд, ЭМСайдын хамтарсан 2019 оны А/178, А144 тоот тушаалаар батлагдсан " Спортын клубыг магадлан итгэмжлэх журам"-ын дагуу нийтлэг шалгуур, үйл ажиллагаа явуулах орчин, эрүүл ахуйн шалгуур, сургалт - дасгалжуулалтын чанарын шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийж шаардлага хангасан тул магадлан итгэмжлэлд оруулаа. | 70 | 70. |
| 2.7. | **Арга хэмжээ:2.8** Монголын үндэсний спортын уламжлалт соёлыг дээдэлж, орон нутагт зохион явуулж буй аливаа арга хэмжээнд дэмжлэг үзүүлнэ. | 20 сая /ЗДҮАХХАХЗ/ | Зохион байгуулсан арга хэмжээнд хамрагдагчдын тоо | 2023 онд үндэсний спортын арга хэмжээнд 2016 иргэн хамрагдсан | Үндэсний спортын арга хэмжээнд хамрагдагчдын тоо 1500-аас багагүй байна. Үндэсний спортын уламжлал соёлыг түгээн дэлгэрүүлсэн байна. | 2024 онд орон нутагт үндэсний сур, шагайн харваа, ширээний шагай, үндэсний бөхийн төрлүүдээр эхний хагас жилд тэмцээн уралдаан 29 удаа хийгдэж давхардсан тоогоор 1760 иргэд хамрагдлаа. Сурын харваа 8 удаа явагдсан давхардсан тоогоор 570 хүн. Шагайн харваа 5 удаа давхардсан тоогоор 895 хүн оржээ.Ширээний шагай 2 удаа тэмцээн зохион байгуулагдаж 45 хүн оролцсон.Үндэсний бөх 14 удаа болж нийт 250 хүн хамрагдсан. | 100 | 100. |
| 2.9. | **Арга хэмжээ:2.9** Аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах | 80 сая /УТ-ний зардал/ | Арга хэмжээ, хамрагдагсдын тоо | 2023 онд 24 спортын төрлөөр 35 аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 4527 | Аймгийн аварга шалгаруулах тэмцээнд хамрагдагчдын | Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг батлагдсан графикт төлөвлөгөөний дагуу насанд хүрэгч, өсвөр үеийн 25 тэмцээн зохион байгуулж 4820 тамирчин оролцсон байна. | 100 | 100. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тамирчин хамрагдсан. | тоо 4800 болж өссөн байна. | | | |
| 2.10. | **Арга хэмжээ:2.10** Улс, бүсийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох, Хэнтий аймгаас төрөн гарсан шилдэг тамирчдыг дэмжин ажиллах | 120 сая /УТ-ний зардал/ 18,5 сая /ЗДҮАХХАХЗ/ | УАШТ-д оролцогчид болон дэмжлэг авсан тамирчдын тоо, УАШТ-д амжилт үзүүлсэн эсэх | 2023 онд 14 спортын төрлийн 27 тэмцээнд оролцож 452 тамирчин хамрагдсан | УАШТ, БАШТ-д оролцогчдын тоо 450-аас багагүй байна. Тив, дэлхий, олон улсын тэмцээнд оролцогчдод дэмжлэг үзүүлсэн байна. | Улс, бүсийн аварга шалгаруулах спортын уралдаан тэмцээнд өсвөр үе, насанд хүрэгчид спортын 22 удаагийн тэмцээнд нийт 669 тамирчид оролцсон байна.Нийт 75,943,200 сая төгрөг зарцуулсан. | 100 | 90 |
| ,2.11. | **Арга хэмжээ:2.11** Оюутны спортын VI наадамд оролцох тамирчдад дэмжлэг үзүүлэх | 5 сая /ЗДҮАХХАХЗ/ | Оролцогчдын тоо, амжилт үзүүлсэн эсэх | - | Амжилттай оролцсон байна. | Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.3.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монголын Оюутны спортын VI наадмын шигшээ тэмцээнд оролцох Хэнтий аймгийн шилдэг оюутнуудад 5.000.000 (таван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | 100 | 100 |
| **Зорилго 3. Төрийн байгууллагын чиг үүргийг хангах** | | | | | | | | |
| 3.1. | **Арга хэмжээ:3.1** Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хэрэгжилт, тайлагналтын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, хууль, журамд заасан хугацаанд харъяалах дээд шатны байгууллагад хүргүүлэх | | Тухайн жилийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээгээр | Тухайн жилийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээгээ 91%-аар үнэлэгдсэн | Тухайн жилийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 70%-иас доошгүй үнэлэгдсэн байна. | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг аймгийн Засаг дарга болон ЗГТА-БТСУХорооны даргаар тус тус батлуулах.Хугацаа нь болоогүй. | 100 | — |
| 3.2. | **Арга хэмжээ:3.2** | | Стратеги төлөвлөгөөни | Стратеги төлөвлөгөөний | Стратеги төлөвлөгөөний | Стратеги төлөвлөгөөний хэрэгжилт 90%. | 100 | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах, тайлагнах, | | й хэрэгжилтийн хувь | биелэлт 2022 онд 91%-тай үнэлэгдсэн. | хэрэгжилтийн хувь 80-аас доошгүй байна. | | | |
| 3.3. | **Арга хэмжээ:3.3** Албан хэрэг хөтлөлтийн стандарт, заавруудын хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллах | Батлагдсан төсвийн холбогдох зардал | Холбогдох журмын дагуу хэрэгжилтийг хангуулсан эсэх | 2024 онд бичиг хэргийн шийдвэрлэлтийн хувь 100% | Бичиг хэргийн шийдвэрлэлтийн хувь 90%-аас доошгүй, стандарт баримталсан байна. | Албан хэрэг хөтлөлтийг холбогдох журмын дагуу стандартыг баримтлан ажиллаж байгаа, бичиг хэргийн шийдвэрлэлт 100% байна. Хугацаа хоцорсон албан бичиг байхгүй.МОНГОЛ БИЧГИЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР- III,2025 оноос төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирилл,үндэсний хос бичгээр хөтлөн явуулах ажлын хүрээнд "Аймгийн Эх хэлний салбар зөвлөл"-өөс санаачлан "Насан туршийн боловсролын төв"-тэй хамтран зохион байгуулж буй анхан шатны үндэсний бичгийн сургалтад нийт 18 албан хаагч хамрагдсан.Мөн монгол бичгээр үйлдэх,баримт бичгийн хэвлэмэл хуудас,түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага,хуудас түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага MNS(6395:2022)-ийн талаар мэдээлэл авч ажиллаа. | 100 | 100. |
| 3.4. | **Арга хэмжээ:3.4** Ирсэн өргөдөл, гомдлыг судлан шийдвэрлэж, хариуг хүргүүлэх, холбогдох журмын дагуу хэрэгжилтийн байдлыг нэгтгэн | | Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувь | 2023 онд шийдвэрлэлтийн хувь 100% | Шийдвэрлэлтийн хувь 95-аас багагүй байна. | Өргөдөл гомдлын шийдвэрлэлт 2024 оны жилийн эцсийн байдлаар иргэн,албан хаагчдаас нийт 11 хүсэлт ирсэн.Үүний 9-н хүсэлтийг шийдвэрлэж ажиллаа.<br>Явсан бичиг-311<br>Ирсэн бичиг-200 хариутай-82<br>Тушаал-А-169<br>Б-25 | 95 | 90. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | холбогдох газарт хүргүүлэх | | | | | | | |
| 3.5. | **Арга хэмжээ:3.5** Төрийн албан хаагчийн сургалт,ажиллах нөхцөл,нийгмийн баталгаар хангах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах | Батлагдсан төсвийн холбогдох зардал | Төрийн албан хаагчийн сургалт,ажиллах нөхцөл, нийгмийн баталгаар хангах төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Төрийн албан хаагчийн сургалт,ажиллах нөхцөл, нийгмийн баталгаар хангах төлөвлөгөөний 2024 оны хэрэгжилтийн 91% | Төрийн албан хаагчийн сургалт,ажиллах нөхцөл, нийгмийн баталгаар хангах төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь 80%-аас доошгүй байна. | Төрийн албан хаагчийн сургалт,ажиллах нөхцөл, нийгмийн баталгаар хангах **27** заалт бүхий төлөвлөгөөг гарган батлуулж хэрэгжилтийг хангаж ажилсан. Жилийн эцсийн байдлаар хэрэгжилт 88%. Үүнд: Хугацаа болоогүй заалт- 5<br><br>Үнэлэх боломжгүй заалт – 5<br>Үнэлсэн заалт – 17<br>Нийт 27 заалт<br>Засгийн Газрын тохируулагч агентлаг,Биеийн Тамир Спортын Улсын Хорооноос 2 удаагийн уулзалт зөвлөгөөн,цахим сургалтад хамрагдсан.. Монголын Үндэсний Олимпын Хорооноос Спортын удирдах ажилтны сургалт-семинарыг 2024 оны 4 дүгээр сарын 2-ноос 05-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо болж амжилттай зохион байгуулагдсан.ЗДТГ-аас төрийн албан хаагчидрүү чиглэсэн нийтдээ 25-н удаагийн сургалтад холбогдох ажилтан албан хаагчдыг 100% хамруулж ажилласан.Мөн Монгол Улсын хөгжлийн бодлого:"Төлөвлөлт, хэрэгжилт,үнэлгээ" сэдэвт богино хугацааны зайн сургалтад 2 албан хаагч хамрагдсан. | 100 | 90 |
| 3.6. | **Арга хэмжээ:3.6** Байгууллагын төсөв, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу | | Байгууллагын батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан | 2024 оны батлагдсан төсөв | Төсвийн зарцуулалт зөрчилгүй байна. | 2024 онд Улсын төсвөөс үйл ажиллагааны санхүүжилт батлагдсан төсөв-999011.8 мян/төг, 12 сарын гүйцэтгэлээр 999011,8 мян/төг, Орон нутгаас батлагдсан төсөв-299854,8 | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах | | эсэх, ирэх оны төсвийн төлөвлөлтийг хугацаанд илгээх | | | мян/төг,12 сарын гүйцэтгэлээр-299854,8 мян/төг ,Өсвөрийн шигшээ багт 150000,0 мян/төг батлагдсанаас 12 сарын байдлаар -150000,0 мян/төг гүйцэтгэлтэй ажилласан.Мөн дээд шатны байгууллагаас тэмцээн уралдаанд 20330,8 мян/төг санхүүжүүлсэн.төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас-3810,0 мян/төг орлого орсон.2023 оны Санхүүгийн тайланд хийсэн Аудитын шалгалтаар "Зөрчилгүй" дүгнэлт авсан мөн акт, зөвлөмж байхгүй өр авлагагүй ажилласан. | | |
| 3.7. | **Арга хэмжээ:3.7** Байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хяналт тавих | | Байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээг жилд 1-ээс доошгүй удаа хийнэ. | 2024 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэнд 1 удаа ХШҮ хийсэн | Жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ 1-ээс доошгүй удаа хийсэн байна. | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэнд төлөвлөгөөнд тусгагдсан гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлтийг үнэлэх журмыг үндэслэн үнэлгээ 1 удаа хийнэ. Хугацаа болоогүй. | ~~100~~ | |
| 3.8. | **Арга хэмжээ:3.8** Дотоод удирдлагын нэгдсэн систем www.erp.e-mongolia.mn-д байгууллагыг холбох, албан хаагчдын хэрэглээг тогтмолжуулах | | www.erp.e-mongolia.mn системд холбогдсон эсэх, системийн хэрэглээ тогтмолжсон эсэх | www.erp.e-mongolia.mn системийг удирдах болон гүйцэтгэх албан хаагчдын тогтмол, бүрэн ашиглаж байна. | www.erp.e-mongolia.mn системд холбогдсон байна, системийг удирдах болон гүйцэтгэх албан хаагчдын бүрэн ашиглалт | - Дотоод удирдлагын нэгдсэн систем www.erp.e-mongolia.mn системийг албан хэрэгцээнд бүрэн ашиглаж байна.Монгол Улсын Засгийн Газрын 2024 оны 07 дугаар сарын 17-ний өдрийн хуралдааны 23 дугаар тэмдэглэлийн 2.4 хэсэгт заасан заалтын хүрээнд Төрийн байгууллагын албан бичиг солилцооны дундын систем 'DOCX'-ийг ашиглан цахим хэлбэрээр баримт бичиг солилцож,төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж байна. | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.9. | **Арга хэмжээ:3.9** Байгууллагын цахим сангийн хөгжүүлэлтийг хийж, үйл ажиллагааг тогтмолжуулан, ил тод байдлыг нэмэгдүүлнэ. | | Цахим сангийн хөгжүүлэлт хийж, үйл ажиллагаа тогтмолжсон эсэх | Цахим сангийн хөгжүүлэлт | Цахим сангийн үйл ажиллагаа тогтмолжсон байна. | Байгууллагын цахим сангийн ажлын хэсгийг даргын тушаалаар баталж, ажлын хэсгийн www.khentii.sport.gov.mn цахим сангийн хөгжүүлэлтийн гүйцэтгэл 80% тай хийгдсэн байна. Мэдээ мэдээллийн баяжилтыг тогтмол хийж байна.Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд хуульд байнга ил тод, нээлттэй байлгахаар заасан мэдээлэл буюу "Шилэн индекс"-ийн үнэлгээний тайланг shilen.gov.mn сайтад хугацаанд нь хүргүүлж ажиллаа. | 100 | 100 |
| 3.10. | **Арга хэмжээ:3.10** Албан хаагчидтай хариуцлагын гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангах, төрийн албан хаагчийн хяналтын хуудсыг хэрэглэх сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн мэдээллийг олон нийтэд мэдээллэн ажиллах | | Хариуцлагын гэрээ байгуулсан эсэх, гомдлын тоо | Үйлчилгээний стандартыг батлуулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажилласан. | Үйлчилгээний стандартын мөрдөж иргэд олон нийтэд гомдол, чирэгдэлгүй ажилласан байна. | Байгууллагын "Үйлчилгээний стандарт"-ын хэрэгжилтийг хангаан ажиллаж байна. Жилийн эцсийн байдлаар 2 албан хаагч хяналтын хуудас цоолуулсан байна.Хэнтий аймгийн Стандарт Хэмжилзүйн газрын даргын даргын 2021 оны 07 сарын 02-ны өдрийн С/30 дугаар тушаалаар батлагдсан стандартыг мөрдөн ажиллах ажлын хүрээнд Салбар сан,сургалт мэдээлэл,Архив бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн:Г.Оюунгэрэл "Стандарттай Монгол" нөлөөллийн аяны хүрээнд сургалт орж албан хаагч нарт зөвлөгөө мэдээлэл өгсөн. | 100 | 100 |
| 3.11. | **Арга хэмжээ:3.11** Авлигын эсрэг үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг батлуулж, | | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 2024 онд шинээр баталсан. | Төлөвлөгөөний хэрэгжилт 85%-аас доошгүй байна. | Авилга, ашиг сонирхлын зөрчлийн талаар иргэд олон нийтийг соён гэгээрүүлэх 2 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 11 албан хаагчийг хамруулсан. Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтанд 21 | 70 | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтийг хангах | | | | | албан хаагч тус тус хамрагдсан ба авилга ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, санал, гомдол тухайн байгууллагад бүртгэгдээгүй болно. Төлөвлөгөөний биелэлт 81% | | |
| 3.12. | **Арга хэмжээ: 3.12** Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Аймгийн албан ёсны вэб сайт www.khentii.mn, болон "Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар" фэйсбүүк пэйжэд орсон мэдээллийг олон нийтэд түгээх /like, share/ | - | Мэдээллийн тоо | 2023 онд спортын 43, биеийн тамирын 72 удаагийн арга хэмжээ, ажил үйлчилгээний мэдээллийг цахим хуудсаараа мэдээлж, ЗДТГазрын цахим хуудаснаас 47 удаагийн мэдээ, мэдээллийг хуваалцаж ажилласан байна. | 50-аас доошгүй удаа мэдээ мэдээлэл бэлтгэж иргэд олон нийтэд хүргэсэн байна. | Иргэд, олон нийтэд "Хэнтий БТСГазар" цахим хуудсаар тогтмол мэдээ мэдээлэл хүргэж ажиллаж байна. 2024 оны жилийн эцсээр Улс, бүс, Аймгийн аварга шалгаруулах 80 удаагийн уралдаан тэмцээн,Нийтийн биеийн тамирийн 60 арга хэмжээ, бусад 92 удаа нийт 176 удаагийн мэдээ мэдээлэл, заавар, удирдамжийг Хэнтий БТСГазар болон БТСУХорооны цахим сайт болон фэйсбүүк хаягт мэдээ мэдээлэл, Нийтийн биеийн тамирын чиглэлээр мэдээлэл, олон нийтэд сурталчилан таниулсан. Мөн сургалт болон бусад үйл ажиллагааны мэдээ мэдээллийг хүргэж ажилласан ба ЗДТГазраас олон нийтэд чиглэсэн 67 удаагийн мэдээ мэдээллийг хуваалцаж иргэдэд хүргэж, байгууллагын болон аймаг, орон нутгийн үйл ажиллагааг сурталчилж ажилласан байна. | 100 | 100 |
| 3.13. | **Арга хэмжээ: 3.13** Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд байгууллага бүр "Ногоон оффисийн шалгуур"-ыг хангаж ажиллах | | Шалгуурыг хангасан эсэх 100% | | Бүх байгууллага шалгуурыг бүрэн хангасан байна. | Өдрийн цагаар, ажлын бус цагаар өрөө, хонгилын гэрлийг унтрааснаар гэрэлтүүлгийн зардлыг 15 хувь хүртэл бууруулж байна. Мөн ажилтнуудын өрөө тасалгаа, заал танхимуудыг 2021 оноос хойш шат дараатайгаар улайсах гэрлийг орчин үеийн хамгийн үр ашигтай гэрэлтүүлэг | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | LED гэрэлтүүлгээр сольсон. Усны хэмнэлт болон хэрэглээнд ухаалаг хандаж, усны тоолуур тавиулж хэрэглээгээ хянаж ажилладаж байна.<br>Ногоон орчин бий болгох, албан ажлын байрныхаа орчинд ногоон байгууламж бий болгох, спортоор хичээллэдэг, уралдаан тэмцээн явагддаг заал танхимуудаа шороо тоос босохыг багасгах, улмаар орчны агаарын чанарт эерэгээр нөлөөлөх зорилгоор өрөөнүүд болон заал, танхимуудыг цэцэгжүүлсэн ба 30 гаруй нэр төрлийн 120 гаруй цэцэг тарьж, тогтмол арчилж байна. | | |
| 3.14 | **Арга хэмжээ: 3.14** Батладсан орон тооны хязгаарт багтаан үйл ажиллагаа явуулах | - | Батлагдсан орон тооны хязгаарт багтаан ажилласан эсэх | | Орон тооны хязгаарт багтаан ажилласан байна. | Батлагдсан орон тооны хязгаарт багтаан үйл ажиллагаагаа явуулж байна.Орон нутгийн биеийн тамир,спортын төрийн захиргааны байгууллагын зарим албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 12 дугээр сарын 05-ны өдрийн 529 дүгээр тогтоолоор баталсантай холбогдуулан байгууллагын бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох талаар арга хэмжээг авч ажиллаа. | 100 | 100 |
| | **Арга хэмжээ: 3.15** 2021 оны А/105 тоот Аймгийн засаг даргын захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллах | | Тайланг хугацаанд нь хүргүүлсэн эсэх | Хугацаа хоцорсон тайлан байхгүй. | Тайлангуудыг 2-р хавсралтын дагуу хугацаанд нь гаргасан эсэх | Аймгийн Засаг даргын 2021 оны А/105 тоот захирамжийн дагуу холбогдох тайлан мэдээг хугацаанд гаргаж ажиллаа. | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **Арга хэмжээ: 3.16** Аймгийн Засаг дарга болон харьяа хэлтэсийн дарга, мэргэжилтний өгсөн хугацаатай үүрэг, чиглэлийг биелүүлж ажиллах | | Хугацаанд нь биелүүлсэн эсэх | Тухай бүрт биелүүлж ажилласан. | Үүрэг даалгаварыг хугацаанд нь биелүүлсэн эсэх | Аймгийн Засаг дарга болон харьяа хэлтсийн дарга, мэргэжилтний өгсөн хугацаатай үүрэг, чиглэлийг биелүүлж ажиллаа. | 100 | 100 |
| | **Арга хэмжээ: 3.17** Аймгийн Засаг даргын захирамжаар баталсан холбогдох ажлын хэсэг, комисс болон салбар зөвлөлийн нарийн бичиг, гишүүний үүргийг гүйцэтгэж, хэрэгжилтийг хангах | | Хэрэгжилтийг хангасан эсэх | 1зөвлөлд гишүүн, 2 ажлыг хэсэгт нарийн бичиг, 2 ажлын хэсэгт гишүүнээр тус тус ажилласан. | Хэрэгжилт, хариуцсан ажлыг хангалттай гүйцэтгэсэн байна. | Аймгийн Засаг даргын Захирамжаар баталсан холбогдох ажлын хэсэг, комисс болон салбар зөвлөлийн нарийн бичиг, гишүүний үүргийг 4 удаа гүйцэтгэж, хэрэгжилтийг хангаж ажиллаа. | 100 | 100 |
| | **Арга хэмжээ: 3.18** Аймгийн Засаг дарга болон харьяа хэлтэсээс зарласан агентлаг байгууллагын дарга нарын хурал, нийтийг хамарсан үйл ажиллагаанд албан чөлөөнөөс бусад тохиолдолд байгууллагын дарга өөрийн биеэр оролцох | | Ирцийн хувь | Ирцийн хувь ... | Ирцийн хувь албан чөлөөнөөс бусад 90%-аас доошгүй байх | Аймгийн Засаг дарга болон харьяа хэлтээс зарласан Агентлаг байгууллагын дарга нарын хурал, нийтийг хамарсан үйл ажиллагаанд албан чөлөөнөөс бусад тохиолдолд байгууллагын дарга өөрийн биеэр оролцсон. Дараагийн шатны албан тушаалтнаар 2 удаа орлуулан суулгасан. | 70 | 70 |
| | **Арга хэмжээ: 3.19** Монгол Улсын сайд, Олимп, | | Хяналтад авсан эсэх | 2023 онд 17 заалтыг | Хяналтандаа авч биелэлтийг хангаж | Хэрэгжилтийг хангаж биелэлтийг зохих маягтын дагуу хугацаанд нь гарган хүргүүлсэн. | 100 | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга аймгийн Засаг дарга нарын хооронд байгуулсан төрийн зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний холбогдох заалтыг хяналтанд авч, бодлогын хэмжээнд шийдвэрлэх асуудлыг агентлагийн дарга өөрийн биеэр харьяа хэлтсийн дарга, мэргэжилтэн болон аймгийн Засаг даргад танилцуулж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах | | | хэрэгжүүлж ажилласан. | ажилласан байна | | | |
| | **Арга хэмжээ: 3.20** Төрийн албан хаагчдыг чадавхжуулах, мэдлэгийг дээшлүүлэх “60 минут нэмэх цэнэг” цахим сургалтад төрийн захиргааны болон төрийн | | Албан хаагчдын хамрагдалт, мэдлэгийн түвшингийн хувь | Албан хаагчид 2024 онд тогтмол хамрагдаж, 2 удаагийн түвшин тогтоох сорилд хамрагдсан | Сургалтын төлөвлөгөөний дагуу албан хаагчдыг бүрэн хамруулж, албан хаагчдын мэдлэгийн түвшин 80 хувьд хүрсэн байна. | 2024 онд Төрийн албан хаагчдыг чадавхжуулах, мэдлэгийг дээшлүүлэх “60 минут нэмэх цэнэг” 11-н цахим сургалтад давхардсан тоогоор 35 албан хаагч хамрагдаад байна.Жилийн эцсийн байдлаар түвшин тогтоох шалгалтад 5 албан хаагч хамрагдаж 18-19 оноо буюу 90%-иас дээш үнэлгээ авсан. | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээний албан хаагчдыг хамруулж, түвшинг хагас, бүтэн жилээр тогтоох | | | | | | | |
| | **Арга хэмжээ 3:21** “1 байгууллага, 1 шинэлэг санаа” арга хэмжээний хүрээнд биеийн тамир, спортын салбарын урьдчилсан үзлэг, тооллогыг төлөвлөн аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх | | Арга хэмжээний гүйцэтгэлээр | - | Гүйцэтгэл 80%-аас багагүй байх | Биеийн тамир, спортын салбарын улсын нэгдсэн тооллого 2024 онд зохион байгуулагдахтай холбогдуулан аймгийн хэмжээний нэгдсэн тооллого хийх. Тооллогыг 2024 оны 12-р сарын 20-ны дотор дуусгахаар тооллогын комисс томилон ажиллаж байна. | - | — |
| | **Арга хэмжээ:3.22** Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хэрэгжилт, тайлагналтын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, хууль, журамд заасан хугацаанд харъяалах дээд шатны байгууллагад хүргүүлэх | | Тухайн жилийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээгээр | Тухайн жилийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээгээ 91% | Тухайн жилийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 70%-иас доошгүй үнэлэгдсэн байна. | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хэрэгжилтийн тайланг дээд шатны байгууллагад хугацаанд нь хүргүүлсэн. | 100 | 100 |
| | **Нийт гүйцэтгэлийн хувь** | | | | | | 96.80 | 97.8 |

*Төлөвлөгөөг хянасан:* **_Төсвийн Ерөнхийлөн захирагч_**

Аймгийн Засаг дарга ............................ /Д.Аюурбунь/

(огноо)

............................ *Тэмдэг*

*Төлөвлөгөө тайлагнасан:* **_Төсвийн Шууд захирагч_**

Хэнтий аймгийн
Биеийн Тамир, Спортын Газрын даргын үүргийг
түр орлон гүйцэтгэгч
*(албан тушаал)*

Солонго ............................ /Г.Солонго/

*(гарын үсэг)*

*(огноо)*

2024.12.15 ............................ *Тэмдэг*

СЮА0036 9075178